



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/23

Өвт

┌ Үнэлгээний хороо байгуулах тухай ┐


Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бат-Өлзий сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны хүүхдийн хоол нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Г.Цэрэндулам (Нийгмийн ажилтан)
Гишүүд: Ш.Базарханд (Ерөнхий боловсролын сургуулийн багш)
Ч.Батдулам (Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч)
И.Маралмаа (Иргэний төлөөлөл)
Нарийн бичгийн дарга: А.Мандахзул (Ерөнхий боловсролын сургуулийн Сургалтын менежер)

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан, мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хороо (Г.Цэрэндулам)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгийг хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, Архив, бичиг хэргийн эрхлэгчид хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (А.Мандахзул)-д үүрэг болгосугай.

ДАРГА 

Н.БАТ-ЭРДЭНЭ